



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 4/07

Мааньг

Баян сумын төсвийн ерөнхийлөн  
захирагчийн 2021 оны орон нутгийн  
хөгжлийн сангийн төлөвлөгөө  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээний техник эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв ажлын даалгаврыг боловсруулан, худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог хууль, журамд заасны дагуу байгуулж сумын Засаг даргад хүргүүлэхийг захиалагч байгууллага Засаг даргын Тамгын газрын дарга Д.Гантөмөр болон төсөвт байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажлыг баталсан хугацаанд шуурхай зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Засаг даргын орлогч /Э.Баянсансар/-д үүрэг болгосугай.
4. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга /А.Нямсүрэн/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.МӨНХ-ЭРДЭНЭ

Сумын Засаг даргын 2021 оны 01... сарын  
04... өдрийн /ХТ/ тоот захирамжийн хавсралт

БАЯН СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2021 ОНЫ ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, нэр, төрөл, тоо хэмжээ, хүчин чадал, багцлалт	Төсөвт өртөг (мян.төг)	2021 онд санхүүжих дүн (мян.төг)	Эрх шилжүүлэх эсэх (ТЭЗ-н нэр/)	ХАА-нд мөрдөх журам	Худалдан авах ажиллагаанд мөрдөх хугацаа				Тайлбар, тодруулга	
						Үнэлгээний хороо байгуулах огноо	Тендер зарлах огноо	Гэрээ байгуулах эрх олгох огноо	Гэрээ дуусгавар болох, дүгнэх огноо		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
<b>ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ШИЛЖИХ ҮЛДЭГДЛЭЭР 2021 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ</b>											
1	Сумын үерийн далан байгуулах	105 000,0	105 000,0		НТШ	2021.01.22	2021.01.25	2021.02.26	2021.12.31		цахим
2	Соёл амралтын хүрээлэнгийн хөл бөмбөгийн талбай байгуулах ажил	117 206,8	117 206,8		НТШ	2021.01.22	2021.01.25	2021.02.26	2021.12.31		цахим
3	Бамбар, Дашгай хорооллын гудамжны гэрэлтүүлэгийн ажил	64 000,0	64 000,0		НТШ	2021.01.22	2021.01.25	2021.02.26	2021.12.31		цахим
4	Цант, Цавчир багт малын угаалтын ванн, хашаа барих	18 000,0	18 000,0		ХА	2021.03.15	2021.03.17	2021.03.25	2021.12.31		цахим
5	Сумын төвийн Бамбар, Дашгай хорооллын худгийг засварлах	10 000,0	10 000,0		ХА	2021.03.15	2021.03.17	2021.03.25	2021.12.31		цахим
6	Соёл амралтын хүрээлэнгийн гүйлтийн зам	40 000,0	40 000,0		ХА	2021.03.15	2021.03.17	2021.03.25	2021.12.31		цахим
<b>ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ШИЛЖИХ ҮЛДЭГДЛЭЭР 2021 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ДҮН</b>											
<b>ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2021 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ</b>											
1	Сумын төвийн гэр хорооллыг дулааны шугамд холбох	400 000,0	400 000,0		НТШ	2021.01.22	2021.01.25	2021.02.26	2021.12.31		цахим
2	Хоолт хороонд гэрэлтүүлэг тавих	83 365,1	83 365,1		НТШ	2021.01.22	2021.01.25	2021.02.26	2021.12.31		цахим
<b>ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2021 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ДҮН</b>											
НИЙТ ДҮН		837 571,9	837 571,9								

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:  
БАЯН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ *Б.Баянсансар* Э.БАЯНСАНСАР  
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА *А.Нямсүрэн* А.НЯМСҮРЭН